

НИЙГМИЙН СЭТГЭЛ СУДЛАЛ-БОЛОВСРОЛ СУДЛАЛ

ХҮҮХДИЙН ЦОГЦ ЧАДАМЖИЙН ХӨГЖИЛ, ТӨЛӨВШЛИЙН ХӨТӨЛБӨРИЙГ СУДАЛСАН АЖЛЫН ҮР ДҮН [®]

Б. Даваажав

*Боловсрол судлалын ухааны доктор (Ph. D.), дэд профессор
Шинжлэх ухаан, технологийн их сургууль. Бизнесийн удирдлага,
хүмүүнлэгийн сургууль*

diq57@yahoo.com

Хураангуй: Хүүхэд авъяас чадвараараа, цогц чадамжийг хөгжүүлэн төлөвшүүлэх онол, арга зүйн үндэс нь насан туршдаа суралцах чанартай боловсролын хөгжлийн үзэл баримтлал, хандлагыг тодорхойлж байна. Хүүхдийн цогц чадамжийн эрх зүйн баримт бичиг нь чанартай боловсролын агуулга, арга зүй, үнэлгээ, үр дүнг нэгдмэл байдлаар илэрхийлж байна.

Хүүхдийн статистикийн тоо баримтыг судлахад 2000-2017 онд тэдний хөгжлийн тоон үзүүлэлт 0,7-8,5 хувь хүртэл дээшилж байгаа ч чанарын үзүүлэлтийг дээшлүүлэх зайлшгүй шаардлага урган гарч байна.

Хүүхдийн цогц чадамжийн хөгжил, төлөвшлийн хөтөлбөр нь авъяас чадварыг хөгжүүлэн, төлөвшүүлэх үйл ажиллагаа, үйл явц, чадваржуулалтын нэгдмэл арга зүйн үндсийг дэвшүүлж байна.

Түлхүүр үгс: Хүний хөгжил, хүний төлөвшил, авъяас, чадвар, цогц чадамж

Судалгааны ажлын тулгамдсан асуудал: Хүүхэд авъяас чадвараараа бие даан сурах, ажиллах, амьдрах, нийгэмшихүйн асуудлыг шийдвэрлэхэд оршино.

Судалгааны ажлын үндэслэл: НҮБ-ын “Тогтвортой хөгжил-2030 хөтөлбөр”-д үндэслэсэн “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д дэвшүүлсэн, хүүхдэд эрүүл амьдрах, чанартай боловсрол эзэмших зорилгыг хэрэгжүүлэхэд тэдний нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад үндэслэж байна [11.]. Энэ нь хүүхдийн бие, нас сэтгэхүйд тохирсон, амьдралын үзэл бодол, итгэл үнэмшил, үнэт зүйлс, үнэ цэнийн тухай шинэ, шинэ чадварыг шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлэн, төлөвшүүлэхыг шаардаж байна.

Судалгааны ажлын зорилго: Хүүхдийн цогц чадамжийн хөгжил, төлөвшилд нөлөөлөх хүчин зүйлсийг судлан, нэгдмэл хөтөлбөрийн арга

зүйн үндсийг шинэчлэн боловсруулж, практикт бүтээлчээр хэрэгжүүлэхэд оршино.

Энэхүү зорилгыг биелүүлэхын тулд дараах зорилтыг дэвшүүлэв.

Үүнд:

-Хүүхэд авъяас чадвараараа, цогц чадамжийг хөгжүүлэн төлөвшүүлэх онол, арга зүйн үндсийг судлах,

-Хүүхдийн авъяас чадвар, цогц чадамжийн талаар тусгасан НҮБ-ын болон өөрийн орны эрх зүйн баримт бичгийг нягтлан авч үзэх,

-Хүүхдийн судлалын статистик судалгааны тоо баримтыг тооцон тайлбарлах,

-Хүүхдийн цогц чадамжийн хөгжил, төлөвшлийн хөтөлбөрийг дэвшүүлэх,

Судалгааны ажлын таамаглал: Хүүхэд авъяас чадвараараа бие даан сурах, ажиллах, амьдрах, нийгэмшихүйн үр дүнд л цогц чадамжийг бүрэлдүүлнэ.

Судалгааны онол, арга зүй: Сэтгэл судлал, боловсрол судлалын онол, арга зүй, хүний хөгжлийн үзэл баримтлал, тогтвортой хөгжлийн үзэл баримтлал

Судалгааны арга зүй: Динамик, харьцуулсан судалгаа, контент анализ

Судалгааны арга: Сэтгэл судлал, боловсрол судлалын судалгааны арга

Судалгааны материал: Олон улсын болон өөрийн орны судалгааны байгууллагын баримт бичиг, тоо, материал

Судалгааны ажлын шинэлэг тал: Хүүхэд авъяас чадвараараа, цогц чадамжийг хөгжүүлэн төлөвшүүлэх онол арга зүй болон эрх зүйн баримт бичгийг үндэслэн, статистикийн судалгааны ажлын үр дүнг тайлбарлах, тэдэнд үзүүлэх нийгмийн хөгжлийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

Өгүүллийн үндсэн хэсэг

Хүүхдийн цогц чадамжийн хөгжил, төлөвшлийн хөтөлбөрийг судалсан ажлын үр дүнг Та бүхэнд дараах 4 үндсэн хэсгээр танилцуулж байна. Үүнд:

1. Хүүхэд авъяас чадвараараа, цогц чадамжийг хөгжүүлэн, төлөвшүүлэх онол, арга зүйн үндсийг судлах

Хөгжлийн тухай онол, арга зүйн үндэс

Хөгжлийн тухай ойлголт нь шинжлэх ухааны үндсэн нэр томъёогоор тайлбараарлагддаг. Хөгжлийн тухай ойлголтыг нэн түгээмэл, ерөнхий байдлаар авч үзвэл: “Хөгжил нь мөнхийн хөдөлгөөнт, тодорхой зүй тогтол бүхий тасралтгүй үргэлжлэх тоо чанарын өсөлт, агуулга хэлбрийн өөрчлөлт, бүтэц үүргийн шилжилтийн үйл явц” гэжээ [1.х 6]. Ийнхүү

хөгжил хэмээх ойлголтыг 2 үндсэн судлагдахууны хүрээнд авч үзлээ. Үүнд:

Хүний хөгжил: “Хүн” төвтэй хөгжлийн үзэл баримтлалд: “Хүний хөгжил нь сонголтыг өргөжүүлэх боломж” хэмээн тодорхойлсон. Энэ нь хүний бие бялдар, оюун ухаан, ёс суртахуун, гоо сайхан, ажиллах чадвар, амьдрах ухаанд гарч буй чанарын ахиц өөрчлөлтийн үр дүн [1.х 6].

Хүний төлөвшил: “Боловсролын багц хууль”-ийн нэр томъёонд “Төлөвшил” нь хүний хүмүүжил, итгэл үнэмшлийн цогц” хэмээн тайлбарлажээ [4. х 3].

Хүний хүмүүжил нь хүнийг хүмүүжүүлэх (хүнжүүлэх), хүн өөрөө хүмүүжих (хүнжих), хүмүүн, хүний хайлан болох насан туршийн хүмүүншлийн үйл явц юм.

1.2. Авъяас, чадварын онол, арга зүйн үндсийг судлах

“Авъяас нь амжилттай сурч, ажиллах боломж олгон, нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааг эзэмших онцлог илрэлийг тусгагч бие хүний сэтгэл зүйн шинж юм” [5. х. 22]. Өөрөөр хэлбэл авъяас нь аливаа үйлийг амжилттай гүйцэтгэх чадвар.

Авъяас чадварыг хөгжүүлэн төлөвшүүлэхэд чухал нөлөөтэй хүчин зүйлс нь хүний ухамсартай үйл ажиллагаа. Энэ нь хүний зорилго чиглэлтэй, бүтээлчээр бие даан суралцах, ажиллах, амьдрах, нийгэмшихүйн үйл явцын нэгдэл юм.

Сэтгэл судлал, боловсрол судлалын ухаанд хүний авъяас чадварын ойлголт, нэр томъёо, тайлбар, агуулга нь улам баяжин өргөжиж байна.

Авъяас чадвар нь ганц нэг, өрөөсгөл шинжээрээ явцуурах бус харин олон талт шинжээрээ өргөн хүрээнд хөгжин төлөвшиж байна. Спорт, урлаг, хэлний, оюуны, ажиллаж хөдөлмөрлөх, зохион бүтээх, удирдан зохион байгуулах авъяас чадвар нь нэгдмэл зүй тогтлоор хөгжин төлөвшдөг ажээ. Хүний хөгжил, төлөвшил нь авъяас чадварыг хөгжүүлэн, төлөвшүүлэх үйл явц. Үүнд л хүний цогц чадамжийн хөгжил, төлөвшлийн мөн чанар нь оршино.

Авъяас билиг – Авъяас сонирхол - Авъяас чадвар – Цогц чадамж

2. Хүүхдийн авъяас чадвар, цогц чадамж талаар тусгасан НҮБ-ын болон өөрийн орны эрх зүйн баримт бичгийг нягтлан авч үзэх нь

2.1. НҮБ-ын Юнескогийн “Цогц чадамжийн суралцахуйн 4 багана”-ыг авч үзэх нь

“Хүний өөрт болон нийгэмд хэрэгтэй туршлагаар бий болсон мэдлэг, чадвар, дадал, үнэлэмжийн нэгдэл, боловсролын оюуны болон дадлын элемент цогц чадамжийн суралцахуйн 4 баганыг суралцагчдад төлөвшүүлэх”-ийг зөвлөсөн [2, х. 43]. Үүнд:

- Сурахуйн чадамж: Мэдэхүйн тулд суралцах
- Ажиллахуйн чадамж: Хийж бүтээхын тулд суралцах
- Амьдрахуйн чадамж: Амьдрахын тулд суралцах
- Нийгэмшихүйн чадамж: Нийгэмшихийн тулд суралцах

2.2. “Тогтвортой хөгжил-2030 хөтөлбөр”-ийн үндсэн заалт нь хүүхдийн ирээдүйн хандлагыг төлөвлөсөн нь

2015 онд НҮБ-ын Ерөнхий Асамблейн 70 дугаар чуулган болж, ТХЗ-ын 17 зорилго, 169 зорилтыг баталж, 2016 оны 1 сарын 1-нээс “Тогтвортой хөгжлийн зорилго” (ТХЗ) албан ёсоор дэлхий нийтээр хэрэгжиж эхэлсэн. Хөтөлбөрт улс орны хүн амын зорилтод бүлгийн эмзэг байдлыг бууруулахад чиглэжээ [11.]

- “Бүх газарт ядуурлыг төгсгөл болгох” /ТХЗ-I/,
- “Өлсгөлөнг устгаж, хоол тэжээлийг сайжруулах, ХАА-г тогтвортой хөгжүүлэх” заалтаар /ТХЗ-II/,
- “Бүх нийтийг эрүүл амьдралтай болгох” /ТХЗ-III/,
- “Бүх нийтийг чанартай боловсрол, тасралтгүй сурах бололцоогоор хангах” заалтаар /ТХЗ-IV/,

2.3. Монгол улсын “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын зорилго” нь хүүхдийн өнөөгийн төлөвийг тодорхойлсон нь

“Иргэн бүр авьяас, чадвараа хөгжүүлэн, үр бүтээлтэй хөдөлмөрлөж, аз жаргалтай амьдрахад шаардагдах мэдлэг, чадвар, чадамжийг эзэмшин, ёс суртахуун, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахиж, үндэсний нийтлэг үнэт зүйлсийг өвлөн насан туршдаа суралцах боломжоор хангах зорилго бүхий үйл ажиллагааны цогц тогтолцоо бүрдүүлэхэд оршино” гэжээ [3, х. 2].

Энэ зорилго нь хүүхэд, авъяас чадвараа хөгжүүлэн төлөвшүүлэх, ажил хөдөлмөр эрхлэх, амжилт гаргах, аз жаргалтай амьдрах, амьдралын чанараа баталгаажуулах онол, арга зүйн жишиг загварын үндсийг дэвшүүлж байна.

Авъяас чадвар–Ажил хөдөлмөр – Амжилт – Аз жаргал – Амьдралын чанар

3. Хүүхэд судлалын статистик судалгааны тоо баримтыг нягтлан тайлбарлах,

3.1. 0-14 насны хүүхдийн тоо, хувь өссөн байдал


1990 онд 0-4 насны хүүхэд 340633, 5-9 насны хүүхэд 291335, 10-14 насны хүүхэд 260968 байсан бол 2017 онд 0-4 насны хүүхэд 393984, 1,1 хувь, 5-9 насны хүүхэд 341311, 1,1 хувиар тус тус өссөн бол 10-14 насны хүүхэд 232601, 0,8 хувь болж буурсан байдал ажиглагдаж байна [11.] /Хүснэгт №1/.



Хүүхэд, насан туршдаа суралцах чанартай боловсролын суурийг бага, өсвөр насанд хөгжүүлэн, төлөвшүүлэх нь эрхэм дээд, нандин үйлс билээ. “Насны багад эрдэм сурвал нэн сайн”. Чухамдаа энэ насанд хүүхэд бие даан сууж сурах, төлөв түвшин байх нь суурь хүмүүжил, төлөвшлийн үндэс болдог.

3.2. Хүүхдийн авъяас, чадварыг хөгжүүлэн, төлөвшүүлэх орчин, нөхцөл сайжирч байгаа нь


2004 онд 696 цэцэрлэг, 710 ЕБС байсан бол 2017 онд цэцэрлэгийн тоо 1416 болж 2,0 хувь, ЕБС-ийн тоо 798 болж 1,1 хувиар тус тус өсжээ [11.] /Хүснэгт №2/.



Хүүхдийн авъяас, чадварыг хөгжүүлэн, төлөвшүүлэх орчин, нөхцөл нь өнгөрсөн 13 жилийн хугацаанд сайжирсан нь тэдэнд эерэгээр нөлөөлөх таатай хүчин зүйлсийн нэг билээ.

3.3. 0-4 насны нийт хүүхдийн тоо болон цэцэрлэгийн хүүхдийн тоо нэмэгдэж байгаа нь

2001 онд 0-4 насны хүүхдийн тоо 228703, байхад цэцэрлэгийн хүүхдийн тоо 83,7 эзэлж байсан бол 2017 онд 0-4 насны хүүхдийн тоо 393984, 1,7 хувь байхад цэцэрлэгийн хүүхдийн тоо 256,7, 3,0 хувийг эзэлжээ [11.], /Хүснэгт №3/.



Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжил, төлөвшлийн үндэс, сэтгэл зүйн онцлог, хувийн хэрэгцээ сонирхол, авъяас чадвар, бүтээлч үйлээрээ хөгжих тэмүүлэл, эрмэлзлэлийн судалж танин мэдэх, бүтээлчээр хөгжүүлэн төлөвшүүлэхэд эцэг эх, багшийн үүрэг, хариуцлага өндөржиж байна.

Хүүхдийн авъяас сонирхлыг илэрхийлэх сониуч зан, содон чанар, бусдаас ялгарах өвөрмөц онцлог шинжийг анхаарч, хөгжүүлэхыг урьдал болгох явдал юм. “Хүүхэд гэдэг сонин байдаг. Хүний чихэнд содон дуулдана”.


3.4. Сургуулийн өмнөх боловсролын /СӨБ/ болон ерөнхий боловсролын сургуулийн /ЕБС/ багшийн тоо нэмэгдэж байгаа нь

2002 онд СӨБ-ын багшийн тоо 3253, ЕБС-ийн багшийн тоо 20752 байсан бол 2017 онд СӨБ-ын багшийн тоо 7745, 2,3 хувь, ЕБС-ийн багшийн тоо 29242, 2,3 хувиар тус тус өсжээ [11.] /Хүснэгт №4/.




Бүх шатны сургуулийн багшийн, багшлахуйн үйл ажиллагаа нь хүүхдийн ухаанын нээж, оюунын ундруулж, сэтгэлийн хөгжөөж, санаагийн дэвжээхэд, дэмжих, зөвлөх, чиглүүлэх, туслахад оршино. Боловсрол судлалын үндсэн ойлголт “ойлгомжтой бол сонирхолтой, оновчтой бол тодорхой” нь ажил, амьдралд хэрэгжиж буйн илэрхийлдэг [2. х 9].

3.5. 5-9 насны болон 10-14 насны хүүхдийн тоо нэмэгдэж байгаа нь
2000 онд 5-9 насны хүүхэд 267504, 10-14 насны хүүхэд 314253 байсан бол 2017 онд 0-4 насны хүүхдийн тоо 341311 1,7 хувь, 10-14 насны хүүхэд 232601 хувийг эзэлжээ [11.] /Хүснэгт №5/.



Бага, дунд, ахлах ангийн хүүхэд, авъяас сонирхлоороо дугуйлан, клуб, гүнзгийрүүлсэн сургалттай ангид элсэн суралцах нь ирээдүйд эзэмших, ажиллаж, хөдөлмөрлөх мэргэжлийн чиг баримжааг зөв сонгох үндэс болж байна. Хүүхдийн авъяас чадварыг тогтвортой хөгжүүлэн, төлөвшүүлэх нь насан туршдаа суралцах чанартай боловсролыг эзэмших үйл явцын илэрхийлэл.


3.6. Сургууль завсардсан хүүхдийн тоо багасаж байгаа нь
2001 онд ЕБС-д нийт 510300 сурагч суралцаж байхад 13730 хүүхэд сургууль завсардсан бол 2014 онд ЕБС-д нийт 505800 сурагч, 0,9 хувь суралцаж байхад 1169 хүүхэд сургууль завсардсан нь 8,5 хувиар буурчээ [11.], /Хүснэгт №6/.



Хүүхдийн хүсэл сонирхлын унтраах, авъяас чадварын бөхөөх, сурч боловсрох эрмэлзлийн дарах нь оюуны хоосрол, ёс суртахууны ялзрал, гэмт хэрэг үйлдэх муу үр дагавартай. “Дургүй ламд дарж байж, сахил хүртээгээд нэмэргүй”-тэй адил хүүхэд дахин сурна, боловсроно, хөгжинө, төлөвшинө гэдэг хэцүү бэрхээ.


3.7. 18 хүртэлх насны хүүхэдтэй, өрх толгойлсон эхчүүд болон 15-19 насанд хүүхэд төрүүлсэн охидын тоо багасаж байгаа нь

2001 онд 18 хүртэлх насны хүүхэдтэй, өрх толгойлсон эхийн тоо 42,416, 1,06 хувь, 15-19 насанд төрсөн хүүхдийн тоо 4,046, 8.1 хувь байсан бол 2017 онд 18 хүртэлх насны хүүхэдтэй, өрх толгойлсон эхийн тоо 38,148, 0,8 хувь, 15-19 насанд төрсөн хүүхдийн тоо 3,539, 4,6 хувиар тус тус буурчээ [11.], /Хүснэгт №7/.



Сургуульд сурч боловсрох, хөгжих төлөвших өсвөр насандаа хүүхэд төрүүлж, өрх толгойлон, нийгмийн халамжийн зорилтод бүлэгт хамрагдана гэдэг эмэгтэй хүний хувьд байж болохгүй, хүнд ачааны үзүүлэлт буурсан нь маш сайн үйл.

3.8. 18 хүртэлх насны ял шийтгүүлсэн хүүхдийн тоо багасаж байгаа нь 2000 онд 18 хүртэлх насны ял шийтгүүлсэн хүүхдийн тоо 990, 80 хувь байсан бол 2017 онд 18 хүртэлх насны ял шийтгүүлсэн хүүхдийн тоо 425, 42,9 80 хувь болтлоо буурчээ [11.], /Хүснэгт №8/.



Мөн сургуульд сурч боловсрох, хөгжих төлөвших өсвөр насандаа гэмт хэрэг үйлдэж, “хоригдол” муу муухай нэрээр дуудуулж, энэ насандаа арилахгүй хар толбо суулгах нь юутай гаслантай.

4. Хүүхдийн цогц чадамжийн хөгжил, төлөвшлийн хөтөлбөрийг дэвшүүлэх, Хүүхдийн цогц чадамжийн хөгжил, төлөвшлийн хөтөлбөрийг дараах үндсэн 4 хэсгээр судлан, шинэчлэн боловсруулж, бүтээлчээр хэрэгжүүлэхэд оршино.

4.1. Хүүхдийн авъяас чадварыг хөгжүүлэн, төлөвшүүлэх үйл ажиллагаа Хүүхдийн авъяас чадварыг хөгжүүлэн, төлөвшүүлэх үйл ажиллагаа нь шинжлэх ухааны үндэстэй, тэдний бие, нас сэтгэхүйд тохирсон, амьдралын үзэл бодол, итгэл үнэмшил, үнэт зүйлс, үнэ цэнийг чадваржуулахад чиглэнэ /Хүснэгт №11/.

№	Авъяас чадварын үндэс	Сургалтын чиглэл	Авъяас чадварыг хөгжүүлэн, төлөвшүүлэх үйл ажиллагаа
1.	Бие бялдын бял чадал /BQ/	Хөдөлгөөн, эрүүл мэнд	Биеийн тамираар хичээллэх, эрүүлжүүлэх, чийрэгжүүлэх, спортын авъяас чадварыг хөгжүүлэх, цэцэрлэг, сургууь, дүүрэг, аймаг, нийслэл, улс, олон улс, тив, дэлхийн, олимпийн тэмцээнд оролцох
2.	Хүн чанар, хүмүүн шинж /HQ/	Харилцаа, зан чанар	Хандлага, харилцааны ур чадварт суралцах, бусдад хүндэтгэлтэй хандах, өөрийгөө зөв илэрхийлэх, хамт олны харилцаанд дасан зохицох, суралцах, нийгэм, хүмүүнлэгийн үйл ажиллагаа, өдөрлөг, аянд оролцох, хамтран зохион байгуулах

3.	Оюун ухааны чадавхи /IQ/	Хэл яриа, математик	Чөлөөт, бүтээлч, шинжлэх ухаанч сэтгэлгээг хөгжүүлэх, авъяас сонирхол, үзэл бодлоороо зохион бичлэг, эссе, төсөл, хөтөлбөр бичих, ерөнхий, суурь ухааны мэргэжлийн уралдаан, олимпиад, дэвжээ тэмцээнд оролцох
4.	Сэтгэл санааны эрч тэнхээ /EQ/ Урлагийн	Хөгжим, дүрслэх урлаг	Үндэсний боловсрол, дэлхийн сонгодог урлаг, соёлын бүтээлтэй танилцах, судлах, суралцах, уулзалт, ярилцлага, семинар, нээлттэй хэлэлцүүлэгт оролцох, зохион байгуулах, урлагийн авъяас чадварыг хөгжүүлэх, цэцэрлэг, сургууь, дүүрэг, аймаг, нийслэл, улс, олон улс, тив, дэлхийн урлагийн үзлэг, наадамд оролцох/
5.	Ажиллах хүчний чадавхи /KQ/	Өөртөө үйлчлэх хөдөлмөр	Ажиллах, хөдөлмөрлөх үйл ажиллагаа, арга барил, эв дүй, чадвар, хандлага, зохион бүтээх, багаар ажиллах, ажиллах хүсэл сонирхолтой байгууллагадаа сайн дурын ажил хийх, үйл ажиллагаа явуулах, сайн дурын ажил хийх, ажиллагаа явуулах, үнэнч шударгаар хөдөлмөрлөх ажил хэрэгч харилцааны ур чадвар, соёлоос суралцах, хамтран ажиллах
6.	Амьдрах ухааны чадавхи /LQ/	Амьдрах ухаан	Амьдралын энгийн дадал, дэглэм, өдрийн цагийн хуваарыг хэвшүүлэх, чөлөөт цагаа зөв боловсон, соёлтой өнгөрөөх

4.2. Хүүхдийн авъяас чадварын хөгжил, төлөвшлийн хөтөлбөр

1. Өөрийгөө судлах, танин мэдэх: Авъяас чадвараа судлах, танин мэдэх нь хүүхэд өөрийгөө мэдрэх, биеэ таних мэддэг. “Биеэ мэдвэл хүн.”
2. Өөрийгөө хөгжүүлэх: Өөрийгөө боловсруулан хөгжүүлж, дуртай, сонирхолтой хичээлийг сонгон судлах, дугуйланд суралцах, шинийг байнга эрэлхийлдэг.
3. Өөрөөр сэтгэн бодох: Аливаа асуудлыг зүй зохистой шийдвэрлэх, ухаалаг шийдвэр гаргах, шинэд тэмүүлэх, шинийг сэдэж санаачладаг.
4. Өөрийн санаа бодлоо зөв илэрхийлэх: Өөрийн сонирхсон, дуртай сэдвээрээ ярилцлага, уулзалт, мэтгэлцээн, хэлэлцүүлэгт санаа бодлоо илэрхийлэх нь ертөнцийг үзэх үзэл санаа төлөвшдөг.
5. Өөрийн авъяас чадвараараа мэргэжлийн чиг баримжаагаа сонгох: Ажиллаж хөдөлмөрлөх хүсэл сонирхлоороо ажил, хөдөлмөр хийж сурах нь ирээдүйн амьдралд бэлтгэгдэж байна гэдгээ ухаарч, ухамсарладаг.
6. Өөрөө хийж чадах /чадамж/: Хүүхэд бодож сэтгэх, хэлж ярихаасаа илүүтэй хийж чадах, чадвартай, чадамжтай байх нь бүтээлч баялагийн эзэн болдог.
7. Өөрөө хийж бүтээх /бүтээмж/: Хүүхэд, хийж чадахаасаа илүү ихийг бүтээж, туурвих нь бүтээлч сэтгэлгээний үр дүн. Шинэ бүтээл, туурвил

нь ажил, хөдөлмөрийн үр дүнгээс илүү эдийн засгийн үр ашгийг дээшлүүлдэг.

8. Өөрийгөө бусдад нээн харуулах: Хичээлийн олимпиад, урлагийн наадам, спортын тэмцээнд амжилттай оролцоход өөрөөрөө бахархдаг.

9. Өөрийн итгэл үнэмшилтэй байх: Хүүхэд нийгэмд гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, эдлэх эрх мэдэл, эзлэх байр сууриа тодорхойлох нь түүний итгэл үнэмшлийг илэрхийлдэг.

10. Өөрийн үнэлэмж: Хүүхэд өөрийн үнэ цэнээ мэдрэх мэдрэмж нь юугаар ч үнэлэшгүй үнэлэмж.

11. Өөрийн сэтгэл ханамж: Хүүхэд өөртөө сэтгэл хангалуун байдлаар илэрдэг.

4.3. Хүүхдийн авъяас чадвар хөгжин төлөвших үйл явц, чадваржуулалт

Хүүхдийн авъяас чадварын /capacity/ бүрэлдэхүүн хэсгийг чадваржуулах /empowerment/, чадварын /skills/ дээшлүүлэх, цогц чадамжийг /competency/ төлөвшүүлэх, нийгэм хүмүүнлэгийн харилцааны үнэт баялагийг /capital/ бүтээхэд оршино.

capacity – empowerment – skills – competency – capital

Хүүхдийн авъяас чадварын чадваржуулалт нь тэдний бие даасан, идэвх санаачлагатай, бүтээлч үйл ажиллагаа юм. Энэ нь хүүхдийн сурч танин мэдэх, хийж бүтээх, чадах, хандаж харьцах явцдаа өөрсдийгөө хөгжүүлэх, хүмүүншүүлэх, төлөвшүүлэх, нийгэмшүүлж байдаг зүй тогтолтой [1. х. 21]. Хүүхэд, мэдээллийг уншихад 10 хувь, сонсоход 20 хувь, харахад 30 хувь, сонсож харахад 50 хувь, өөрсдөө хийхэд 80 хувь, өөрсдөө хийж бүтээн, суралцахад 90 хувийг танин мэдэж, хийж бүтээж, чадаж, хандаж харьцдаг нь эрдэмтэн, судлаачдын судалгааны ажлын үр дүнг баталсан.

“Хүн нь бие, оюун, хэлний нэгдэл” хэмээн дорны гүн ухаанд номолдог.

Цогц чадамж: “... эзэмшсэн мэдлэг, чадвар, туршлага, төлөвшсөн хандлага, зан үйлийн илэрхийлэл, хүний хөгжлийн чадамж”. Хүүхдийн сурахуйн, ажиллахуйн, амьдрахуйн, нийгэмшихуйн авъяас чадварын цогц чадамжийн хөгжил, төлөвшлийн нэгдмэл тогтолцоонд судаллаа /Хүснэгт №12/.

Хүүхдийн авъяас чадвар, цогц чадамжийн хөгжил, төлөвшил

Сурахуйн	Ажиллахуйн	Амьдрахуйн	Нийгэмших
Сонсох Зурах Харах Бичих	Бүтээх өрсөлдөх Хөрвөх Үнэнч шударгаар хөдөлмөрлөх	Хэрэглээний соёл Сонголт боломж Зүй зохистой хэрэглээ, Хэмнэлт	Хууль зүй Ёс зүй Хүмүүнлэг ёс зүй
мэдээллийг боловсруулах	мэдлэгийг бүтээх	Баялгийг үйлдвэрлэх	Хэрэглэгч, үйлчлэгч, нийгэм үйлчлэх
Амны уншлага	ажлын дадлага	амьдралын туршлага	Нийгмийн харилцаанд дасан зохицох
Аргыг олбол бэрхийг давна.	Арга сайтын ажил сайн.	Ажил сайтын амьдрал сайн.	Амьдрал сайтын амжилт их.
Харилцан сурах	хамтран ажиллах	Амьдралын чанар, сайхнаар бахархах	Хамтдаа хөгжих, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах

Хүүхдийн авъяас чадвар нь цогц чадамжаар тодорхойлогдоно. Зөв явдалтай, зөөлөн сэтгэлтэй, зохист харьцаатай, зүйтэй хүүхэд. Хүүхэд өөрийгөө хайрладаг, өрөөлийг хүндэлдэг, өрөвч сэтгэлтэй, өвөрмөц сэтгэлгээтэй, өндөр чадвартай, өрнүүн тэмүүлэлтэй, өөдрөг хүн болж хөгжин төлөвших явдал юм. Хүүхэд эрүүл чийрэг бие бялдартай, саруул уужим оюун ухаантай, цэвэр ариун ёс суртахуунтай байх нь түүний цогц чадамжийн нэгдлийг тогтолцоонд оршдог.

4.4. Хүүхдийн баялаг нь нийгмийн баялгийг бүтээх үйл явц

Хувь хүний баялаг нь өргөн утга агуулгаараа мэдлэг, чадвар, хандлагын нэгдлийг илэрхийлсэн эдийн засгийн үндсэн ойлголт. Улс орны хөгжлийг тодорхойлоход хувь хүний баялаг нь эдийн засаг, санхүүгийн хөрөнгө оруулалт, техник технологийн шинэчлэлтээс ч шийдвэрлэх нөлөөтөй, чухал байр суурийг эзлэнэ [1. х. 20].

Хүүхдийн нөөц чадавхид тулгуурласан хувь хүний баялгийг /Human capital/, нийгмийн баялаг /Social capital/ болгож хөгжүүлэх, өөрчлөн шинэчлэх үйл явцад мөн чанар нь оршино.

Human capital - Social capital

Нийгмийн баялаг нь нийгэм, хүмүүнлэгийн харилцааны үнэт баялгийг бүтээн, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөх явдал юм. Нийгмийн баялаг нь “Нэгдмэл зорилгоо хэрэгжүүлэхын тулд хамт олон дотоодоо эвсэг найртайгаар хамтран ажиллах чадвар” юм. Чухамдаа “хүүхдийн тус багадаггүй”.

Сайн үйлс бүтээх сайхан сэтгэлтэй, сайн санаатай хүүхэд нь нийгэм, хүмүүнлэгийн харилцааны эрхэм нандин баялгийг бүтээгч билээ. “Сэтгэлийн угтаа зөв санаатай”.

5. Судалгааны ажлын дүгнэлт:

1. Хүүхэд авъяас чадвараараа, цогц чадамжийг хөгжүүлэн төлөвшүүлэх онол, арга зүйн үндэс нь насан туршдаа суралцах чанартай боловсролын хөгжлийн үзэл баримтлал, хандлагыг тодорхойлж байна. Үүнд л хүүхдийн суурь хүмүүжил, төлөвшлийн мөн чанар нь оршино.

2. Хүүхдийн цогц чадамжийн эрх зүйн баримт бичиг нь чанартай боловсролын агуулга, арга зүй, үнэлгээ, үр дүнг нэгдмэл байдлаар илэрхийлж байна.

3. Хүүхдийн статистикийн тоо баримтыг судлахад 2000-2017 онд тэдний хөгжлийн тоон үзүүлэлт 0,7-8,5 хувь аажим өсөж байгаа ч чанарын үзүүлэлтийг дээшлүүлэх зайлшгүй шаардлага урган гарч байна.

4. Хүүхдийн цогц чадамжийн хөгжил, төлөвшлийн хөтөлбөр нь авъяас чадварыг хөгжүүлэн, төлөвшүүлэх үйл ажиллагаа, үйл явц, чадваржуулалтын нэгдмэл арга зүйн үндсийг дэвшүүлж байна. Хүүхдийн баялаг нь нийгмийн баялгийг бүтээхэд оруулж буй бодит хувь нэмрээр илэрч байдаг.

6. Судалгааны ажлын санал, зөвлөмж

-Хүүхэд судлалын судалгааны ажлын багийг эрдэмтэн, судлаачдын бүрэлдэхүүнтэй байгуулан, хамтран ажиллах

-Хүүхэд авъяас чадвараараа, цогц чадамжийг хөгжүүлэн төлөвшүүлэх үйл ажиллагааны онол, арга зүйн үндэслэн, өөрийн хөгжил, төлөвшлийн хөтөлбөр боловсруулах,

-Хүүхдийн үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийн эрх зүйн жишиг загварын үндсийг сайжруулах,

-Хүүхэд судлалын статистик судалгааны мэдээллийн сан бүрдүүлэх, шинжлэх ухааны эргэлтэнд оруулах,

-Хүүхдийн цогц чадамжийн хөгжил, төлөвшлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, бодит үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэгжүүлэх.

НОМ ЗҮЙ

[1] Батнасан Б. Хүний хөгжил. сурах бичиг. 2008 он

[2] Жамц Л. Боловсрол судлал. Сурах бичиг. 2009 он

- [3] Монгол улсын төрөөс баримтлах боловсролын бодлого. 2015 он
- [4] Монгол улсын боловсролын багц хууль. 2005 он
- [5] Мягмар О. Сэтгэл судлал. сурах бичиг. 2011 он
- [6] Мянганы хөгжлийн зорилт илтгэл. 2009 он
- [7] “Нийгмийн хөгжил” лекц. 2011 он.
- [8] “XXI зууны бүтээлч хөдөлмөр”. Эрдэм шинжилгээний хурал. 2018.
- [9] Эрдэм шинжилгээний өгүүлэл
- [10] www.Open government.com
- [11] www.1212.mn